

“МОНГОЛЫН ЦАХИЛГААН ХОЛБОО” ХК-ИЙН КОМПАНИЙН ЗАСАГЛАЛЫН КОДЕКСИЙГ ХЭРЭГЖҮҮЛЭХ ХӨТӨЛБӨР

НЭГ. НИЙТЛЭГ ҮНДЭСЛЭЛ

1.1. Энэхүү “Монголын цахилгаан холбоо” ХК (цаашид “Компани” гэх)-ийн компанийн засаглалын кодексийг хэрэгжүүлэх хөтөлбөр (цаашид “Хөтөлбөр” гэх)-ийн зорилго нь Компанийн дотооддоо мөрдөх бодлогын баримт бичиг, дүрэм, журам, зааврыг эрх бүхий зохицуулах байгууллагаас баталсан “Компанийн засаглалын кодекс”-ийн зарчимд нийцүүлэн баталгаажуулах, түүнийг дагаж мөрдсөнөөр компанийн засаглалын зарчмуудыг үйл ажиллагаандаа нэвтрүүлж, хэвшил болгоход оршино.

ХОЁР. ХӨТӨЛБӨРИЙН ЗОРИЛТ, ХЭРЭГЖҮҮЛЭХ ҮЙЛ АЖИЛЛАГАА

2.1. Компанийн засаглалын кодексийг хэрэгжүүлэх хөтөлбөрийн хүрээнд дараах зорилтыг хэрэгжүүлэн ажиллана.

2.1.1. Хувьцаа эзэмшигчийн эрхийг баталгаажуулах;

2.1.2. Төлөөлөн удирдах зөвлөл /цаашид ТУЗ гэх/ болон гүйцэтгэх удирдлагын хариуцлагын тогтолцоог олон улсын жишигт хүргэх;

2.1.3. Тайлагнал, мэдээллийн ил тод байдлыг сайжруулах;

2.1.4. Эрсдэлийн удирдлагыг сайжруулах;

2.1.5. Хяналтын тогтолцоог сайжруулах.

2.2. Хөтөлбөрийн хүрээнд дараах үйл ажиллагааг хэрэгжүүлнэ. Үүнд:

2.2.1. Компанийн тухай болон Үнэт цаасны зах зээлийн тухай хууль, “Компанийн засаглалын кодекс”-т тусгагдсан бодлогын баримт бичиг, дүрэм, журам, зааврыг компанийн засаглалын үндсэн зарчим, хэм хэмжээнд нийцүүлэн баталж, мөрдүүлэх;

2.2.2. Компанийн бодлогын баримт бичиг, дүрэм, журам, зааврын хэрэгжилтэд комплайнсын хяналтыг тогтмол хэрэгжүүлэх;


2.2.3. Эрх бүхий албан тушаалтан, ажилтныг компанийн засаглалын сургалтад хамруулах;

2.2.4. Хөтөлбөрийн хэрэгжилтийг тайлагнах, мэдээлэх;

2.2.5. Тайлагнал, мэдээллийн ил тод байдлыг хангах үйл ажиллагааг хариуцах этгээдийг тодорхой болгох.

ГУРАВ. ХӨТӨЛБӨРИЙН ЗОХИОН БАЙГУУЛАЛТ

3.1. Энэхүү хөтөлбөрийг ТУЗ нь өөрийн компанийн бизнесийн цар хүрээ, үйл ажиллагааны онцлог, бүтэц, зохион байгуулалтад нийцүүлэн баталж, хэрэгжилтэд хяналт тавина.



3.2. ТУЗ нь дараах чиглэлээр бодлогын баримт бичиг, дүрэм, журам, зааврыг баталж, мөрдөнө. Үүнд:

3.2.1. дүрэм, журам, бодлогын баримт бичиг, заавар;

3.2.1.1. Ёс зүйн дүрэм;

3.2.1.2. Залгамж халааны бодлогын баримт бичиг;

3.2.1.3 Нэр дэвшүүлэх хорооны журам;

3.2.1.4. Цалин, урамшууллын хорооны журам;

3.2.1.5. Аудитын хорооны журам;

3.2.1.6. Дотоод хяналтын бодлогын баримт бичиг;

3.2.1.7. Ногдол ашгийн журам;

3.2.1.8. Эрсдэлийн удирдлагын заавар, журам;

3.2.1.9. Дотоод аудитын журам;

3.2.1.10. Комплайнсын хяналтын заавар, журам;

3.2.1.11. Хувьцаа эзэмшигчдийн хурлын журам;

3.2.1.12. ТУЗ-ийн нарийн бичгийн даргын үйл ажиллагааны журам;

3.2.1.13. Мэдээллийн ил тод байдал, тайлагналын журам;

- Хөрөнгө оруулагчтай харилцах хөтөлбөр;
- Гүйцэтгэх захирлын үйл ажиллагааны журам;
- Их хэмжээний болон сонирхлын зөрчилтэй хэлцэл хийх журам;
- Оролцогч талуудтай харилцах, хамтран ажиллах журам;
- Ажилтны санал, хүсэлт, талархал, гомдол хүлээн авах, шалгах, барагдуулах, хариу өгөх журам.

ДӨРӨВ. ТАЙЛАГНАЛ, ҮНЭЛГЭЭ

4.1. ТУЗ нь Компанийн дүрэм, бодлогын баримт бичиг, заавар, журам, загварыг боловсруулах, мөрдүүлэх чиглэлээр хэрэгжүүлсэн арга хэмжээний үр дүн, явцын талаар жил бүрийн хувьцаа эзэмшигчдийн ээлжит хуралд тайлагнана.

4.2. ТУЗ нь хөтөлбөрийн хэрэгжилтийн тайлан, компанийн засаглалын үнэлгээг компанийн үйл ажиллагааны тайланд тусгаж, компанийн цахим хуудсанд байршуулах бөгөөд тухайн үйл ажиллагааг ТУЗ-ийн нарийн бичгийн дарга хариуцна.

4.3. ТУЗ нь жил бүрийн эхний улиралд багтааж, компанийн засаглалыг үнэлэх асуулгын дагуу өөрийн компанийн засаглалын түвшинг үнэлж болно.

4.4. ТУЗ нь хөтөлбөрийн хэрэгжилтийн тайланг жил бүрийн 4 дүгээр сарын 30-ны өдрийн дотор эрх бүхий зохицуулах байгууллагуудад холбогдох журмын дагуу хүргүүлэх бөгөөд тухайн үйл ажиллагааг ТУЗ-ийн нарийн бичгийн дарга хариуцна.

ooOoo